



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 581

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх ухааны академийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 21,630,000.00 (хорин нэгэн сая зургаан зуун гучин мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг худалдах хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Шинжлэх ухааны академийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн захирал Х.Цогтбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



0002587

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн
381... дугаар тогтоолын хавсралт

Шинжлэх ухааны академийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
акталж, данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Д/д	Автомашини марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Автомашинийг акталж, сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ
1	Мицубиши Делика, 28-32 УБК, суудлын, арал: P35W0601948	1996/2004	395,300	4,800,000.00	4,800,000.00	-	200,000.00
2	Ниссан Патрол, 05-04 УБО, суудлын, арал: NZ002738	1995/2001	483,700	16,830,000.00	16,830,000.00	-	500,000.00
Нийт дүн				21,630,000.00	21,630,000.00	-	700,000.00
				(хорин нэгэн сая зургаан зуун гучин мянган)		(долоон зуун мянган)	